

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ
10 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 10-р сарын 22-ны өдөр хуралдаж хуралдаанаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдааныг товлох тухай, Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнуулах иргэдийг уламжлах тухай, “Өрх бүр үйлдвэрлэгч” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай, өмчийн тухай гэсэн асуудлуудыг хэлэлцэж баталсан байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдааныг 2020 оны 11-р сарын 03-ны өдрийн 11.00. цаг гэж товлон баталлаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийг аймгийн хэмжээнд 105 хэсгийн хороодод 1505 төрийн албан хаагч ажиллаж, 10-р сарын 15-ны өдрийн 07.00 цагаас 20.00 цагийн хооронд хууль журмын дагуу зохион байгууллаа.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгууль 10-р сарын 15-ны өдөр болохтой холбогдуулан “Согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах үйл ажиллагаанд хязгаарлалт хийх тухай” аймгийн Засаг даргын 2020 оны 10-р сарын 13-ны өдрийн а/729 дүгээр захирамж гарч 10-р сарын 14, 15-ны өдрүүдэд аймгийн хэмжээнд согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдахыг хориглох арга хэмжээг авч ажилласан.

Цаг агаарын гаралтай гамшгийн эрсдэл, өвөлжилтийн бэлэн байдал, коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, ган бүхий аймгуудад эрсдэлийн үнэлгээ хийх, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллах зорилгоор Улсын онцгой комиссын шуурхай бүлэг 10-р сарын 02-ны өдөр Архангай аймагт ажиллаж, аймгийн Онцгой комиссыг хуралдуулсан.

Энэ үеэр аймгийн Эрүүл мэндийн газраас коронавируст халдвараас сэргийлэх, бэлэн байдлыг хангах талаар хэрэгжүүлж байгаа ажил, эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдал, эрүүл мэндийн байгууллагуудын өвөлжилтийн бэлэн байдлын талаар, Ус, цаг уур, орчны шинжилгээний төвөөс Архангай аймгийн 2020 оны зуншлагын байдал, 2020-2021 оны бэлчээрийн даац, цаг агаарын урьдчилсан төлөвийн талаар, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангуулах ажлын танилцуулга мэдээлэл хийсэн.

Төрөөс барилгын салбарын талаар баримталж буй барилгын материал, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын хяналтыг сайжруулах зорилгын хүрээнд “Барилгын материал үйлдвэрлэлийн улсын зөвлөгөөн”-ийг 10-р сарын 05-ны өдөр аймгийн төвд зохион байгууллаа.

Зөвлөгөөнд УИХ-ын гишүүн Ё.Баатарбилэг, Барилга хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, дэд сайд Э.Золбоо, аймгийн Засаг дарга Ц.Мөнхнасан, Барилгын хөгжлийн төвийн захирал Ц.Амарсанаа, тэргүүн дэд захирал Б.Ганболд, дэд захирал бөгөөд ерөнхий инженер Б.Энхболд, дэд захирал М.Ибрай болон бусад албаны хүмүүс, 21 аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо, 21 аймгийн барилгын материал үйлдвэрлэгчид, нийт 250 төлөөлөгч оролцож барилгын салбарт 2020-2024 онд авч хэрэгжүүлэх бодлого, барилгын материалын чанарт тавигдах шаардлага, анхаарах асуудал, үйлдвэрлэлд тулгамдаж буй асуудал, барилгын хог хаягдлыг дахин боловсруулах зэрэг илтгэл тавьсан байна.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Татвар төлөлт

2020 оны 10 сард улсын төсөвт 161750.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 161750.0 мянган төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 100 хувиар, орон нутгийн төсөвт 851936.4

мянган төгрөг төвлөрүүлэхээс 851936.4 мянган төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 100 хувь биелүүлэхээр байна.

“Хасу”, “999”, “Тэрх” худалдааны төвүүдэд үйл ажиллагаа эрхлэгч 162 татвар төлөгчид зөвлөгөө өгч нээлттэй хаалганы өдөр зохион байгууллаа

Хөрөнгө оруулалт

2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 49.076.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 63 төсөл арга хэмжээ хэрэгжихээр төлөвлөгдсөнөөс 9-р сарын байдлаар 11.783.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 4.133.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 50 төсөл арга хэмжээ хэрэгжинэ.

Үүнээс, авто замын сангийн хөрөнгөөр 435.0 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээнээс 18.5 сая төгрөгийн, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3.565.3 сая төгрөгийн 25 төсөл, арга хэмжээ хэрэгжихээс 1.018.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 132.7 сая төгрөгийн 3, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 427.2 сая төгрөгийн зардлаар 13 төсөл арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан байна.

Санхүүгийн хяналт

Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын 1, 5 дугаар сургуулийн үйл ажиллагаанд аудит хяналт шалгалт хийж байна. Эрдэнэбулган сумын 2, 3, 4 дүгээр сургуулиудын 2018-2019 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж ажил сайжруулах зөвлөмж болон хугацаатай үүрэг өгч илэрсэн зөрчилд улсын байцаагчийн 2 төрлийн актаар 30.1 сая төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоогдсоныг аймгийн төсөвт төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн. 10-р сарын байдлаар 0.5 сая төгрөгийн төлбөр барагдсан байна.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Хууль, хяналт

10-р сард гал түймэр, ослын 5 дуудлага хүлээн авснаас объектын галын дуудлага 2, эрэн хайх, аврах үйл ажиллагаа 1, газар хөдлөлт 1, гол нуурын усанд унаж осолдсон 1-ыг тус тус дуудлага ирсэн байна. УЦУОШТ-с цаг агаарын мэдээ 4 удаа тодотгосон, хойд бүсээс 3, хойд бүст 2, ОБЕГ-с 3 мэдээ хүлээн авч удирдлагад танилцуулсан, ОБЕГ-т 3 мэдээг дамжуулсан, ОБЕГ-н “Онцгой” станцаар 110, утсаар 115, мессенжрээр 244, “Зүүм” цахим программаар 56 удаа сүлжээнд орж мэдээ дамжуулж, хүлээн авч ажилласан. Тус аймгийн сумдын Засаг дарга, ЗДТГазрын дарга нарт цаг агаарын аюулт үзэгдлийн мэдээг 1 удаа, covid-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх анхааруулах, сэрэмжлүүлэх мэдээ, мэдээллийг 120 удаа цаг алдалгүй дамжуулж бүртгэл хөтөлж ажилласан байна.

Монгол Улсын Шадар сайдын баталсан удирдамжийн дагуу аймгийн төв Эрдэнэбулган суманд үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрийн барилга байгууламжид Гамшгаас хамгаалах тухай хууль, галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, Гал түймрийн улсын хяналтын дүрэм, стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 10-р сарын 01-нээс 18-ны өдрүүдэд зохион байгуулж нийт 7 байгууллага хамрагдаж 72 зөрчил илрүүлж, 25 зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулан бусад зөрчлүүдийг арилгуулахаар Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 4, мэдэгдэл 3-ийг тус тус бичиж байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж 34 зөрчлийг тус тус арилгуулсан байна.

Байгаль орчин, аялал жуучлалын сайдын баталсан “Яндангаа хөөлье” удирдамж, Онцгой байдлын ерөнхий газрын тэргүүн дэд даргын баталсан “Яндангаа хөөлье” аяны хүрээнд хийж хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу гэр хорооллын айл өрхүүдийн пийшин зуухны аюулгүй байдал, галын аюулгүй байдлыг хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалт явуулах удирдамжийн дагуу төлөвлөгөөг гарган газрын даргаар батлуулан хэрэгжүүлэн ажиллалаа.

Аяны хүрээнд Эрдэнэбулган сумын 1 дүгээр багийн 1-30 дугаар гудамж, 2 дугаар багийн 1-30 дугаар гудамж, 3 дугаар багийн 1-35 дугаар гудамж, 4 дүгээр багийн 1-38 дугаар гудамж, 5 дугаар багийн 1-35 дугаар гудамж, 7 дугаар багийн эрчим, тамир, цаг уурын хорооллын айл өрхүүдийг алба хаагч нарт хувиарлан нийт 898 айл өрхөд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн 842 санамж гарын авлага тараан ажилласан.

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, яндангаа хэрхэн зөв хөөлөх, гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдрийн шторкыг “АВ” телевизээр өдөрт 10 удаагийн давтамжтайгаар нийт 3000 минут нэвтрүүлсэн.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар 10-р сарын 20-ны өдөр Цэнхэр, Төвшрүүлэх сумдын ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгүүдийн ерөнхий боловсрол, сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагаа, эрүүл ахуй, халдвар хамгаалал, хоол үйлдвэрлэл нөхцөл, соёлын төвийн ажил үйлчилгээ, түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт, хамгаалалт хэрхэн хангагдаж буй байдал, хүнсний дэлгүүрийн эрүүл ахуй нөхцөл шаардага хэрхэн хангагдаж буйд төлөвлөгөөт хяналт шалгалт хийлээ.

2020 оны 9-р сард аймгийн хэмжээнд 349 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 100, хулгайлах гэмт хэрэг 149, иргэдийн өмчийн гэмт хэрэг 53, малын хулгайн гэмт хэрэг 86, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 21, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 78, гэмт хэргийн илрүүлэлт 48.0 хувьтай байна.

Нийт 22018 захиргааны зөрчил бүртгэгдсэнээс Зөрчлийн тухай хуулийн дагуу 21371 иргэнд 698.2 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 1235.3 сая төгрөг, нөхөн төлүүлэлтийн хувь 46.1 хувьтай байна.

Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 10-р сард 2640933.2 төгрөгийн мөнгөн дүн бүхий 564 гүйцэтгэх баримт бичиг ирснээс шийдвэр гүйцэтгэх бодит биелэлтийн хувь 50, мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлт 39.5 байна.

Шүүхийн шинжилгээний алба 10-р сард криминалистикийн шинжилгээ 2, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт 65, шүүх эмнэлгийн 115 шинжилгээ хийсэн байна.

Стандарт, хэмжил зүйн хэлтэс Засгийн газрын 100 хоног, Стандартын өдөр, Стандарт хэмжил зүйн ажилтны өдрийг тохиолдуулан өөрчлөлт шинэчлэлтийн жил уриан дор сарын аян зохион байгуулж аяны хүрээнд салбарт мөрдөгдөж буй хууль тогтоомж, дагалдан гарсан дүрэм, журам, стандарт, байгууллагын үйл ажиллагаа, цаг үеийн бусад мэдээ, мэдээллийг орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэж, сургалт зохион байгуулсан байна.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд Боловсрол

Дэлхийн багш нарын 26, Монголын багш нарын 54 дэх өдрийг 10-р сарын 02-ны өдөр аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёл, урлагийн газар хамтран зохион байгуулсан бөгөөд “Багшийн хөгжил” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан “Бүтээлч байгууллага”, “Бүтээлч багш” уралдааны шилдэг сургууль, багш нарын шагнал болон Засгийн газрын салбарын “Боловсролын тэргүүний ажилтан”-аар 33, “Боловсролын яамны жуух”-аар 53, аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр 8, аймгийн “Тэргүүний ажилтан”-аар 6, аймгийн “Засаг даргын жуух”-аар 32, аймгийн “Хүндэт өргөмжлөл”-өөр 8, “Багшийн алдар” медалиар 23, “Ахлах багш” тэмдэгээр 25, “Аргазүйч” тэмдэгээр 28 багш тус тус шагнаж урамшуулсныг аймгийн удирдлагууд гардуулсан.

Мөн энэ үеэр Өгийнуур, Өлзийт, Хашаат, Хайрхан, Хотонт, Цэцэрлэг, Эрдэнэбулган сумын 5, Ирээдүй сургуулиудын “Багшийн хөгжлийн төв”-д тус бүр 4.0 сая, нийт 32.0 сая төгрөгийн техник тоног төхөөрөмжийг олголоо. 2018-2020 онд нийт 20 сургуулийн Багшийн хөгжлийн төвийг 80.0 сая төгрөгийн техник тоног төхөөрөмжөөр хангаад байна.

Эрдэнэбулган сумын 7-р багт БНХАУ-ын буцалтгүй тусламжаар хүүхдийн 100 ортой Хүүхдийн цэцэрлэг баригдаж, Эрдэнэбулган сумын 15-р цэцэрлэгээр бүртгэгдэж ашиглалтад орж үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 10-р сарын 12-ны өдрийн А/721 дүгээр захирамжийн дагуу “Хөдөөгийн багш нарын спортын ээлжит 18-р наадам”-ыг 10-р сарын 29-31-ний өдрүүдэд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байгаа бөгөөд наадамд 8 аймаг оролцохоор мэдүүлгээ ирүүлээд байна.

Соёл, урлаг

Аймгийн Номын сан нийтийн уншлагын танхимаар 30 шинэ уншигч шинээр бүртгэж, 400 ирэгсэд, 500 номоор, хүүхдийн уншлагын танхимаар 129 уншигч шинээр бүртгэж, 360 ирэгсэд, 500 номоор, гэрээр ном олгох үйлчилгээгээр нийтийн уншлагын танхимаар 30 ирэгсэд, 55 ном, 80 тогтмол хэвлэлээр, үндсэн фондоос 24 уншигч шинээр бүртгэж, 75 ирэгсэд, 208 ном олгож, нийтийн уншлагын танхимд 65 уран зохиолын шинэ ном, хүүхдийн уншлагын танхимд монгол ардын аман зохиолын 50 ширхэг шинэ номын үзэсгэлэн гаргасан байна.

Аймгийн Музей “Соёлын цаг” аяны хүрээнд Эрдэнэбулган сумын 8, 2, 4, 11-р цэцэрлэгийн хүүхдүүдэд монгол гэр барих арга ухаан, Монгол гэрийн иж бүрдэлийг зааж сурган, Ихтамир сумын Соёлын төвтэй хамтран тус сумын ЕБСургуулийн 12а ангийн сурагчдын дунд Монголын уламжлалт тоглоом наадгай болон хөгжөөнт тоглоомоор буухиа тэмцээн зохион явуулж шалгарсан сурагчдыг дурсгалын зүйлээр шагналаа.

Мөн Эрдэнэбулган сумын 3-р сургуулийн дунд ангийн сурагчдад үндэсний уламжлалт тоглоом наадгайг танилцуулж, гарын авлага тарааж, Ахмадын баярын өдрийг тохиолдуулан аймгийн ахмадын холбоотой хамтран 25 хүнд музейг үнэ төлбөргүй үзүүлсэн байна.

Гадаад дотоодын аялагч, үзэгчдийн үйлчлүүлэх ая тухтай орчин нөхцөлөөр хангах, музейн орчныг сайжруулах зорилгоор, аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу орчин үеийн стандартад нийцсэн нийтийн бие засах газар барих ажлыг “Эсгэл” ХХК 64 сая төгрөгийн төсөвт өртгөөр хийж гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 70%-тай байна.

Аймгийн Хөгжимт драмын театр “Соёлын цаг” хөтөлбөрт аяны хүрээнд Эрдэнэбулган сумын 2, 4, 8, 11-р цэцэрлэг, 3-р сургууль, Спортын төрөлжсөн 5-р сургууль, Ихтамир суманд амжилттай зохион байгуулж байгууллагын үйл ажиллагааны талаарх гарын авлага танилцуулж, урлагийн тогтлолт зохион байгуулж, үзэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа санал асуулга авч, энэхүү үйл ажиллагаанд нийт цэцэрлэгийн насны дунд, ахлах бүлгийн 500 гаруй хүүхэд, ЕБС-ийн бага, дунд бүлгийн 600 гаруй сурагчид хамрагдсан байна.

Эрүүл мэнд

Аймгийн Засаг даргын 2020 оны 10-р сарын 06-ны өдрийн “Өвөлжилтийн бэлтгэл ажилтай танилцах ажлын хэсгийн удирдамж”-ийн дагуу 2020 оны 10-р сарын 08-ны өдрөөс Чулуут, Хангай, Цахир, Тариат, Өндөр-Улаан сумдын Эрүүл мэндийн төвүүдийн өвөлжилтийн бэлтгэл ажилтай танилцаж, өвөлжилтийн бэлтгэл ажилд дүгнэлт хийсэн.

“Эх, хүүхдийн эмгэг судлал” сэдэвт 2 өдрийн бүсчилсэн сургалтыг 10-р сарын 19-ны өдөр Эмгэг судлалын үндэсний төвтэй хамтран зохион байгуулж сургалтад аймгийн Нэгдсэн эмнэлэг, өрхийн Эрүүл мэндийн төвийн эмч нар, Баянхонгор, Өвөрхангай аймгуудын эмгэг судлаач болон эс судлаач эмч нар хамрагдсан.

ЭХЭМҮТөвийн уушигны тасгаас зохион байгуулсан Томуу, томуу төст өвчний тархалтын үед хүүхдэд үзүүлэх яаралтай тусламж үйлчилгээний бодлогын баримт бичиг, эмнэлзүйн заавар, бэлэн байдлын үнэлгээ, Лаборатори болон дүрс оношилгооны чадавхийн үнэлгээг ЭМЯ-ны хүүхдийн өвчин хариуцсан мэргэжилтэнтэй хамтран 10-р сарын 3, 4-ний өдүүдэд Нэгдсэн эмнэлгийн Яаралтай тусламж, эрчимт эмчилгээ, Хүүхдийн тасаг, Лаборатори, дүрс оношилгооны тасгуудад хийсэн.

Элэгний хавдрын урдьчилан сэргийлэх үзлэг хэт авиан оношилгоонд 6 сумын 567 иргэнийг хамруулж, элэгний хавдар 5, умайн хавдар 1, элэгний хавдартай 9 иргэнд хяналтын үзлэг хийсэн.

Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/146 дугаар тушаалын хавсралтаар 2020-2021 оны хичээлийн жилд нийт 51 эмнэлгийн мэргэжилтэн үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалтад хамрагдахаар батлагдсны дагуу 2020 онд нийт 43 хүнийг хамруулаад байна. Анхан шатны эрүүл мэндийн төвүүдийн 5 их эмчийг эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн эмчийн баримжаа олгох 1 сарын сургалтад хамруулсан. Үндсэн мэргэшлийн сургалтад нийт 25 эмч шалгалт өгснөөр 20 эмч суралцах эрхээ авсан.

Жаргалант, Тариат сумдад түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх авто машины парк шинэчлэлт 58 сая төгрөгөөр хийгдэж түргэн тусламжийн шуурхай байдал хангагдаад байна. Хашаат, Төвшрүүлэх сумдын эрүүл мэндий төвд авто машины парк шинэчлэлт хийх хүсэлтийг ЭМЯаманд хүргүүлсэн. Хангай сумын эрүүл мэндийн төвд түргэн тусламжийн авто машины парк шинэчлэлт хийгдэхээр шийдвэрлэгдсэн.

Дархлаажуулалтын 10 хоногийг “Томуугаас сэргийлье” уриан дор зохион байгуулж, нийт 5156 хүнийг томуугийн эсрэг дархлаажуулалтанд хамруулж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах үйл ажиллагааг зохион байгуулж, нийт 1788 хүн, 18 суманд “Халдварт болон халдварт бус өвчний цогц илрүүлэг үзлэг”-ийг зохион байгуулж, давхардсан тоогоор 7300 орчим иргэнийг үзлэг, оношилгоонд хамруулсан.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал

2020 оны 10-р сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхитэй хайгч 627 иргэн бүртгэлтэй байгаагаас 331 эмэгтэй. Шинэ ажлын байр 766 үүнээс байнгын ажлын байр 430, улирлын ажлын байр 44, түр ажлын байр 292 байна. Ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 719, зуучлал 693 байна. 10-р сарын 19-ний байдлаар 130 иргэн шинээр бүртгүүлж, LMIS программд шивж оруулсан. Ажил идэвхитэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр ангилвал: боловсролгүй-5, бага-13, суурь-106, бүрэн дунд-374, техникийн болон мэргэжлийн анхан шатны-18, тусгай мэргэжлийн дунд-8, Дипломын бакалаврын-103 иргэнийг тус тус бүртгэж мэдээллийн бааз үүсгэсэн, ажилгүйдлийн тэтгэмж авахаар ирсэн 8 иргэнийг LMIS програмд шивж оруулан тодорхойлолт гарган өгч Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлсэн.

Нийгмийн даатгалын санд 2020 оны 9-р сарын 30-ны байдлаар нийт 15.5 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 112.0 хувиар биелүүлсэн байна. Давхардсан тоогоор 14.5 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд нийт 48.3 тэрбум төгрөг зарцуулжээ. Улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн тэтгэвэрт 5309.2 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд шилжүүлжээ.

Нийгмийн даатгалын санд 2020 онд 15.6 тэрбум төгрөгийн сангийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.5 тэрбум төгрөгөөр өссөн.

Ажил олгогч, даатгуулагчаас төлсөн шимтгэлийн орлогыг дараах байдлаар нийгмийн даатгалын сангуудад хуваарилсан байна. Үүнд

Тэтгэврийн даатгалын санд 66.4 % буюу 11025.5 сая төгрөг

Тэтгэмжийн даатгалын санд 7.3 % буюу 1167,4 сая төгрөг;

ҮОМШӨ-ний даатгалын санд 5.6 % буюу 518.8 сая төгрөг;

Ажилгүйдлийн даатгалын санд 1.5 % буюу 259.4 сая төгрөг;

Эрүүл мэндийн даатгалын санд 19.2% буюу 2594.2 сая төгрөг

2020 оны нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд нийт 45.3 тэрбум төгрөг зарцуулжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад сангийн зардал 7.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Гэр бүл, хүүхэд, залуучууд

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар “Хөөрхөн зүрх” ТББ-тай хамтран гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх, олон талт хамтын ажиллагааг сайжруулах уулзалтад 11, гэр бүлийн харилцааг сайжруулах, хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга эзэмшүүлэх сургалтад Хашаат, Хотонт сумдын 51 хүнийг тус хамруулсан.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Мал аж ахуй

Малчдын түвшинд 80.0 мянган тн өвс 1300 тн тэжээл болон бусад нэмэгдэл тэжээл хужир шүүг бэлтгүүлэхээр төлөвлөсөн. Үүнээс өөрийн аймгийн болон Төв, Сэлэнгэ, Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Увс зэрэг аймгуудын нутгаас малчдын түвшинд 50.0 мянган тн өвс, 2681 тн ногоон тэжээл, 1155 тн гар тэжээл, 6.8 тн үйлдвэрийн тэжээл, 98.6 тн давс хужир шүүг нөөцлөн аваад байна. Тэжээл бэлтгэл 70 орчим хувьтай байна. Дорнод, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс аймгуудаас иргэд 20.0 мянган боодол буюу 40 гаруй тн өвсийг авч ирэн 9.0-12.0 мянган төгрөгөөр худалдан борлуулж байна.

Засгийн газрын тогтоолын дагуу 2020 онд аймгийн аюулгүй нөөцөд 1200 тн өвс, 200 тн тэжээл, сумдын нөөцөд 5700 тн өвс, 1330 тн тэжээл бэлтгэхээр төлөвлөсөн. Хангай, Тариат, Эрдэнэмандал, Булган, Цахир, Эрдэнэбулган, Өндөр-Улаан, Хайрхан сумдын аюулгүй нөөцөд 465.2 тн өвс, 89.2 тн тэжээл бэлтгэн нөөцөлсөн байна.

Сэлэнгэ аймгийн Засаг даргад хадлангийн талбай шийдвэрлэн өгөх талаар албан хүсэлт хүргүүлсний дагуу тус аймгийн нутагт өвс бэлтгэж буй иргэн аж ахуй нэгжүүдтэй хамтран өвсийг газар дээрээс нь 4000-5000 төгрөгөөр худалдан борлуулах, авах гэрээ байгуулан аймгийн аюулгүй нөөцөд 13.0 мянган боодол буюу 325 тн өвсийг татан авах алыг зохион байгуулж байна.

Бэлчээрийн даац ачааллыг бууруулах зорилгоор мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах, Малын цахим бүртгэл, эрүүл мэндийн мөшгөх тогтолцооны системээр гарал үүслийг тодорхойлж нийт 90.9 мянган толгой малыг зах зээлд гарал үүслийн бичигтэйгээр борлуулсан байна.

Газар тариалан

Ургацын төлөв байдлын мэдээг 7 хоног бүрийн Баасан гарагт гарган, хүргүүлдэг бөгөөд 10-р сарын байдлаар төмс 264.5 га-д тариалж 3174 тн ургац, хүнсний ногоо 139.5 га-д тариалж 1395 тн, улаан буудай 2720 га-гаас 2308 тн, арвай 10 га-гаас 12 тн, хошуу будаа 165 га-гаас 165 тн, ногоон тэжээл 3910 га-гаас 8089,4 тн хураан авсан бөгөөд нийт ургац хураалтын ажил 60 хувьтай байна. Мөн цаг агаарын цочир хүйтрэлт болж 10-р сарын 19-20-нд шилжих шөнө цасаар шуурснаар Улаан буудайн 2000 орчим га талбай цасанд дарагдсан байна.

2012 оноос хойш Хөдөө аж ахуйг дэмжих сангаас хөнгөлөлттэй нөхцөлөөр бага оврын трактор зээлээр авсан 16 сумын 336 иргэн, аж ахуй нэгжийн 979.3 сая төгрөгийн өр төлбөрийг 2020 онд багтаан барагдуулах талаар хамтран ажиллах албан бичгийг сумдын Засаг дарга нарт хүргүүлэн зээлийн эргэн төлөлтөнд хяналт тавин ажиллаж байна.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Байгаль орчин, аялал жуулчлал

Аймгийн хэмжээнд 2020 оны намрын “Мод тарих аян”-ны хүрээнд нийтээр мод тарих өдрийг 10-р сарын 10-ны өдөр зохион байгуулж, нийт 6500 ширхэг мод, бут сөөгийг нийтийн эзэмшлийн сад, цэцэрлэгт хүрээлэнд тарьж, усалгаа хамгаалалтын ажлын хийлээб Үүнээс 800 ширхэг мод, 5700 ширхэг бут сөөгийг 120 орчим аж ахуйн нэгж, байгууллагын 3871 иргэн мод тарих ажилд оролцсон байна.

“Байгаль эн тэргүүнд аян”-ы хүрээнд хууль бус байгалийн нөөц баялгийн ашиглалт, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлыг 20 удаа зохион байгуулж зохих зөвшөөрөл, эрхийн бичиггүйгээр ойгоос мод, дагалт баялаг бэлтгэж, ашигласан 3 иргэний зөрчлийг илрүүлж, хууль хяналтын байгууллагад шилжүүллээ.

Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын (ОНТХГ) нөхөрлөлүүд, сумдын сайн дурын бүлгийн гишүүдийг чадавхжуулах ой, хээрийн түймэр, ойн менежмент болон байгаль орчны багц хуулийн хэрэгжилт, байгаль орчны хяналт шалгалт сэдэвт сургалтыг, аймгийн Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Сум дундын ойн анги, Лондонгийн амьтан судлалын нийгэмлэгтэй хамтран зохион

байгуулж, сургалтад 10 нөхөрлөлийн 200 гишүүнийг танхимын болон дадлага сургалтад хамруулж мэдлэг чадварыг нь дээшлүүлсэн байна.

Хүнс, үйлдвэрлэл, үйлчилгээ

Шинэ коронавирусийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх тухай аймгийн Засаг даргын 2020 оны 02 дугаар албан даалгаварт тусгагдсан хүн амыг хүнсний хомсдол үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлж, нөөцийн судалгааг гарган ажиллаж байна. Сүүлийн 7 хоногийн судалгаагаар мах 1 тн буюу 1 хоног, гурил 234 тн буюу 31 хоног, гоймон 27.7 тн буюу 2 хоног, будаа 89.9 тн буюу 24 хоног, сахар 59.5 тн буюу 24 хоног, ургамлын тос 23.9 тн буюу 13 хоног, давс 21.2 тн буюу 53 хоног, ундны ус 48.5 мян.л буюу 1 хоног, хуурай сүү 4.3 тн буюу 3 хоног, төмс 28.7 тн буюу 11 хоног, хүнсний ногоо 15.3 тн буюу 1 хоног, өндөг 0.85 тн буюу 1 хоногийн нөөцтэй байна.

Барилга, дэд бүтэц

Архангай аймагт 2020 онд улсын төсвийн хөрөнгөөр 79 тэрбум 378.9 сая төгрөгийн өртөг бүхий 41 төсөл арга хэмжээ, ОНХС-ийн хөрөнгөөр 955.0 сая төгрөгийн өртөг бүхий 8 төсөл арга хэмжээ, БСШУС-ын сайдын багцын 1 тэрбум 703.6 сая төгрөгийн өртөг бүхий 22 төсөл арга хэмжээ, нийт 82 тэрбум 37.5 сая төгрөгийн өртөг бүхий 71 төсөл арга хэмжээний захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

10-р сард 7 барилгыг байнгын ашиглалтанд хүлээн авсан. Үүнд: Чулуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн барилгын засвар, аймгийн хог хаягдал бууруулах ажил, Эрдэнэмандал сумын Соёлын төв, спорт заалны засвар, Эрдэнэмандал сумын 15 ортой эмнэлгийн барилга, Аялал жуулчлалын замын тэмдэг, тэмдэглэгээ, Хүнсний ногооны механикжсан зоорь, Хотонт сумын Соёлын төвийн барилга тус тус ашиглалтад орсон

Цагаан даваагаар зорчин өнгөрч буй тээврийн хэрэгслүүд түр зогсолт хийн, аюулгүй байдлаа хангах зорилгоор Цагаан давааны ард болон урд талд тус бүр 50 метрийн урт, 9 метрийн өргөнтэй авто зогсоолын ажлыг “Саруул харгуй” ХХК гүйцэтгэж, ашиглалтад хүлээлгэн өглөө.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

-----oOo-----